



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2020 оны 12 сарын 28 өдөр

Дугаар 722

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө олж авах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8 дахь хэсэг, 14 зүйлийн 2 дахь хэсгийн 4, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 3.2, 3.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Дорнод их сургуулийн албан хэрэгцээнд зориулан өөрийн хөрөнгийн эх үүсвэрээр 2021 онд нийт 52,500,000.00 (тавин хоёр сая таван зуун мянга) төгрөгт багтаан үндсэн хөрөнгө олж авахыг зөвшөөрч, санхүүжилтийн дүн, үнийн дээд хязгаарыг хавсралтаар баталсугай.

2. Дорнод их сургуулийн захирлын үүрэг гүйцэтгэгч Э.Ундармаад дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай.

2.1. Үндсэн хөрөнгө худалдан авах ажлыг холбогдох хууль, тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2022 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т даалгасугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

13701944

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2020 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн
17.12.27 дугаар тогтоолын хавсралт

**ДОРНОД ИХ СУРГУУЛИЙН ӨӨРИЙН ХӨРӨНГИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭР
2021 ОНД ОЛЖ АВАХ ҮНДСЭН ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ**

Д/д	Эргэлтийн бус хөрөнгийн төрөл, нэр	Хэмжих нэгж, тоо хэмжээ	Барьж эхэлсэн (эхлэх) он	Нийт төсөвт өртөг (төгрөг)	Санхүүжилт хийсэн дүн (2020.12.31-ний байдлаар, төгрөг)	Барилгын гүйцэтгэлийн хувь (%)	2021 онд зарцуулах санхүүжилтийн дүн (төгрөг)
1. Барилга байгууламж, их засвар							
1	Дотоод засвар /НХСалбар, БУБСалбар/	М.КВ		8,400,000.00			8,400,000.00
2	Дотоод засвар /Сургуулийн орох хэсэг/	М.КВ		10,000,000.00			10,000,000.00
3	Гадна хашаагаар орох хэсэг /Сургуулийн хашаа орох хэсэг/	М.КВ		5,000,000.00			5,000,000.00
Барилга, байгууламж, өргөтгөл, их засварын нийт дүн							23,400,000.00

Д/д	Эргэлтийн бус хөрөнгийн төрөл, нэр	Хэмжих нэгж	Тоо, хэмжээ	Нэг бүрийн үнэ (төгрөг)	2021 онд худалдан авах (нийт) үнийн дээд хязгаар (төгрөг)
3. Тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмж					
1	Канон	Ш	1	6,000,000.00	6,000,000.00
2	Хөгжим, техник хэрэгсэл	Ш	1	5,000,000.00	5,000,000.00
3	Сургалтын Ямаха хөгжим, чихэвч	Ш	10	600,000.00	6,000,000.00
4	Төгөлдөр хуур	Ш	1	3,000,000.00	3,000,000.00
Хэсгийн дүн					20,000,000.00
4. Тавилга, эд хогшил, бусад үндсэн (биет бус) хөрөнгө					
1	Ухаалаг самбар	Ш	3	1,500,000.00	4,500,000.00
2	Номын сангийн фонд баяжуулалт	Ш	92		4,600,000.00
Хэсгийн дүн					9,100,000.00
НИЙТ ДҮН					52,500,000.00 (тавин хоёр сая таван зуун мянга)